

БАТЛАВ
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД ЕРӨНХИЙ
ИНЖЕНЕР Б.ГАНХУЯГ

2019 оны 4-р сарын 26 нд.

УТААНЫ ХИЙН НАЙРЛАГА ХЭМЖИХ ЗӨӨВРИЙН ХЭМЖҮҮР "TESTO-310" –ИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Testo 310 Утааны хий шинжлэгч нь хэмжилтийн өндөр нарийвчлал бүхий энгийн функцтэй шаталтын системийн үндсэн хэмжилтүүдийг хийхэд тохирсон хэмжүүр юм. Хэмжүүрийн батарей нь бүрэн цэнэгээрээ 10 хүртэлх цагийн турш ажиллах баталгаатай. Testo -310 нь авч явахад хялбархан, авсаархан хийцтэй хийгдсэн нь өдөр тутмын ажилд зориулсан хэрэгсэл болдог.

Шаталтын анхан шатны болон илүү нарийн түвшний шинжилгээг хийж гүйцэтгэх, зуухны засвар үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах, зуухны ашигт үйлийн коэффициентийг шалгахад ашиглах боломжтой.

TESTO-310 нь конусан хийцтэй хязгаарлагч бүхий зэвэрдэггүй гангаар хийгдсэн зондтой (probe), сонгогдсон хэмжилтийн функцийг харуулах дээд дэлгэц, энгийн тэмдэглэгээ бүхий товчлууртай. Асааснаас хойш 30 секундын дараа шинжилгээ хийхэд бэлэн болдог.



Testo 310 хэмжүүрийн иж бүрдэл (стандарт хэрэгсэлтэй).

Хэмжих хэмжигдэхүүнүүд:

- Утааны хий дэх O₂, CO, CO₂
- Орчны CO
- Даралт болон хурд
- Утааны хийн болон орчны температур
- Илүүдэл агаарын коэффициент

Хүргэлтийн багц: TESTO-310 утааны хий шинжлэгч, хамгаалалтын хайрцаг (hard case), цэнэглэгддэг батарей, үндсэн USB кабель, даралт хэмжигч резинэн хоолой, фильтр 5 ш, туршилт тохируулгын баримт бичиг(protocol), 180 мм урт зонд (конусан хязгаарлагчтай), даралтын хоолойн штуцер.

Техникийн үндсэн тодорхойлолт

Хэмжээ	8 x 3 x 2 инч / 201 x 83 x 44 мм
Ажиллагааны үеийн температур	23° ... 113° F / -5° ... +45°С
Дэлгэцийн төрөл	LCD
Дэлгэцийн функц	Гэрэлтдэг, 2 шугамт дэлгэц
Цахилгаан хангамж	Батарей: 1500 mAh, үндсэн нэгж 5V / 1A
Хадгалах температур	-20° ... +50°С
Жин	Зондын хамт бохиороор 700 гр

ХЯНАСАН: ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА



Л.ГАНБОЛД

БОЛОВСРУУЛСАН: ЗУУХНЫ ГОРИМЫН ИНЖЕНЕР




Г.БАТСАЙХАН

2019 оны 4-р сарын 26.

Хэмжүүрийн иж бүрдэл



TESTO-310 утааны хий шинжлэгч



Хамгаалалтын хайрцаг (hard case)



Цэнэглэгч USB кабель



Фильтр 5 ш



Даралт хэмжигч резинэн хоолой, штуцер